ХУУЛЬ БУСААР БАЙГАА ИРГЭДИЙГ БУЦААН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар (цаашид "Талууд" гэх),

хоёр улсын хооронд сайн хөршийн болон түншлэлийн харилцааг хөгжүүлэх, мөн янз бүрийн салбарт хамтран ажиллах хүсэл эрмэлзлэлийг удирдлага болгон,

хоёр улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харьяалалгүй хүн орох, зорчихтой холбогдсон журмыг зөрчиж зорчсон этгээдийг буцаах, хүлээж авах болон шилжүүлэн өгөх журмыг тодорхойлсон зарчим, хэм хэмжээг тохиролцож нэвтрүүлэх нь шилжилт хөдөлгөөний үйл явцыг зохицуулах чухал бүрдэл хэсэг болох бөгөөд хууль бус шилжилт хөдөлгөөнтэй тэмцэхэд хувь нэмэр болно гэдэгт итгэл төгс байж,

нутаг дэвсгэрт нь хууль бусаар нэвтэрсэн, эсхүл дамжин өнгөрсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хүлээлгэх хариуцлагыг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу тогтоох Тал тус бүрийн улсын бүрэн эрхийг хүндэтгэн,

энэхүү хэлэлцээр нь олон улсын эрх зүйн дагуу, түүний дотор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн дагуу Тал тус бүрийн улсын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг хөндөхгүй болохыг цохон тэмдэглэж,

шилжилт хөдөлгөөний салбарын харилцааг зохицуулж буй өөрсдийн дотоодын хууль тогтоомжийнхоо уялдаа холбоог сайжруулах талаар Тал тус бүрийн улсын сонирхол өсөн нэмэгдэж буйг тэмдэглэн,

дараахь зүйлийг тохиролцов:

1 дүгээр зүйл
Тодорхойлолт

Энэхүү хэлэлцээрт хэрэглэсэн нэр томьёо нь дор дурдсан утгыг илэрхийлнэ:

"хууль бусаар байгаа иргэдийг буцаан шилжүүлэх" гэж гадаадын иргэн, харьяалалгүй хүн нутаг дэвсгэрт нь орох, гарах болон зорчих харилцааг зохицуулж буй хүсэлт гаргагч Талын улсын хууль тогтоомжийг зөрчиж нутаг дэвсгэрт нь орсон, эсхүл зорчсон этгээдийг энэхүү хэлэлцээрт заасан журам, нөхцөл, зорилгын дагуу хүсэлт гаргагч Талын улсын эрх бүхий байгууллага шилжүүлэн өгөх, хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий байгууллага хүлээж авах ажиллагааг;

"хүсэлт гаргагч Тал" гэж улсынх нь эрх бүхий төв байгууллага хууль бусаар байгаа аливаа этгээдийг энэхүү хэлэлцээрийн дагуу буцаан шилжүүлэх хүсэлт гаргасан Талыг;

"хүсэлт хүлээн авагч Тал" гэж улсынх нь эрх бүхий төв байгууллага хууль бусаар аливаа этгээдийг энэхүү хэлэлцээрийн дагуу буцаан шилжүүлэх хүсэлт хүлээн авсан Талыг;

"эрх бүхий байгууллага" гэж энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд оролцож буй Тал тус бүрийн улсын холбогдох байгууллагыг;

"эрх бүхий төв байгууллага" гэж энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндсэн үүрэг ногдсон Тал тус бүрийн улсын эрх бүхий байгууллагыг;

"улсын хилийн боомт" гэж Тал тус бүрийн улсын хууль тогтоомж, эсхүл олон улсын гэрээний дагуу тогтоосон Монгол Улсын хил, эсхүл Оросын Холбооны Улсын хилээр нэвтрэх боомтыг;

"гүйцэтгэх протокол" гэж энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх журмын тухай гүйцэтгэх протоколыг тус тус хэлнэ.

2 дугаар зүйл
Тал тус бүрийн улсын иргэнийг буцаан шилжүүлэх

1. Хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий байгууллага нь хэрэв хүсэлт гаргагч Талын улсад гадаадын иргэн, харьяалалгүй хүн орох, гарах болон зорчих талаарх хууль тогтоомжийг зөрчиж тус улсын нутаг дэвсгэрт орсон, эсхүл зорчиж буй этгээд хүсэлт хүлээн авагч Талын улсын иргэн болох нь тогтоогдсон байвал тухайн этгээдийг, түүнчлэн хүсэлт гаргагч Талын улсын нутаг дэвсгэрт эрх чөлөөгөө хасуулж хорих ял эдлэсэн хүсэлт хүлээн авагч Талын улсын

иргэнийг хүсэлт гаргагч Талын улсын эрх бүхий төв байгууллагын хүсэлтийн дагуу хүлээн авна.

2. Шаардлагатай тохиолдолд, хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий байгууллага тухайн улсын хилээр нэвтэрч ороход шаардлагатай бичиг баримтыг буцаан авч буй этгээдэд хүсэл зоригоос нь үл хамааран олгоно.

3. Тухайн этгээд хүсэлт хүлээн авагч Талын улсын иргэний харьяалалтай эсэхийг нотлох бичиг баримтыг гүйцэтгэх протоколд тусгав. Талууд дээр дурдсан бичиг баримтын загварыг гүйцэтгэх протокол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн дотор дипломат шугамаар солилцоно. Улмаар, Тал тус бүр эдгээр бичиг баримтын загварт орсон аливаа өөрчлөлтийн талаар нөгөө Талдаа дипломат шугамаар нэн даруй мэдэгдэнэ.

4. Хэрэв энэ зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан бичиг баримтын аль нь ч байхгүй бол Тал тус бүрийн улсын эрх бүхий байгууллага тухайн буцаан шилжүүлэх этгээдийн иргэний харьяаллын талаар мэдээлэл авах зорилгоор хүсэлт гаргагч Талын улсын нутаг дэвсгэрт уг этгээдтэй ярилцлага хийх талаар тохиролцоно.

5. Хэрэв тухайн этгээдийг шилжүүлж авсны дараа хүсэлт хүлээн авагч Талын хийсэн шалгалтаар түүнийг буцаан авах үндэслэлгүй ("андуурч буцаан шилжүүлэх" гэх) байсан нь тогтоогдвол хүсэлт гаргагч Талын улсын эрх бүхий байгууллага уг шилжүүлсэн этгээдийг шилжүүлж өгсөн өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн дотор буцаан хүлээж авна. Энэ тохиолдолд хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллага тухайн этгээдийн талаарх өөртөө байгаа бүх бичиг баримтыг хүсэлт гаргагч Талын улсын эрх бүхий төв байгууллагад шилжүүлэн өгнө.

3 дугаар зүйл
Буцаан шилжүүлэх тухай хүсэлт

1. Буцаан шилжүүлэх этгээдийг шилжүүлэн өгөхийн тулд хүсэлт гаргагч Талын улсын эрх бүхий төв байгууллага хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллагад буцаан шилжүүлэх тухай хүсэлтээ хүргүүлэх шаардлагатай.

2. Буцаан шилжүүлэх этгээд нь хүсэлт хүлээн авагч Талын улсын иргэний харьяалалтайг нотлох хүчин төгөлдөр бичиг баримттай тохиолдолд буцаан шилжүүлэх тухай хүсэлт хүргүүлэх шаардлагагүй. Ийм этгээдийг гүйцэтгэх протоколын 7 дугаар зүйлд заасан буцаан шилжүүлэх журмын дагуу шилжүүлнэ.

4 дүгээр зүйл
Буцаан шилжүүлэх тухай хүсэлт гаргах болон түүнийг шийдвэрлэх хугацаа

1. Хүсэлт хүлээн авагч Талын улсын иргэн тухайн хүсэлт гаргагч Талын улсын нутаг дэвсгэрт хууль бусаар орсон, эсхүл хууль бусаар зорчсон болохыг тогтоосон тохиолдолд хүсэлт гаргагч Талын эрх бүхий төв байгууллага буцаан шилжүүлэх тухай хүсэлтээ илгээх боломжтой.

2. Хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллага нь хууль бусаар байгаа иргэдийг буцаан шилжүүлэх тухай хүсэлтийг хүлээж авсан өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн дотор энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийг хүлээж авах зөвшөөрөл, эсхүл тухайн этгээдийг шилжүүлэх нөхцөл бүрдээгүй болохыг хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий байгууллага тогтоосон тохиолдолд түүнийг хүлээн авахаас татгалзсан үндэслэл бүхий хариу өгнө. Тухайн этгээдийг буцаан шилжүүлэх тухай хүсэлтийн хариуг хугацаанд нь өгөхгүй хууль зүйн, эсхүл бодит саад бэрхшээл учирсан тохиолдолд хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллагын бичгээр гаргасан үндэслэл бүхий хүсэлтийг харгалзан хариу өгөх хугацааг хуанлийн 60 хүртэлх хоногоор сунгаж болно.

3. Буцаан шилжүүлэх тухай хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд татгалзсан шалтгаанаа дурдана.

5 дугаар зүйл
Шилжүүлэн өгөх болон хүлээн авах хугацаа

1. Тал тус бүрийн улсын эрх бүхий төв байгууллага тухайн тодорхой тохиолдолд өөрөөр тохиролцоогүй бол хүсэлт хүлээн авагч Тал буцаан авахыг зөвшөөрсөн этгээдийг тухайн зөвшөөрлийг хүсэлт гаргагч Тал хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн дотор шилжүүлэн өгнө.

2. Хэрэв буцаан шилжүүлэх этгээдийг хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий байгууллагад шилжүүлэхэд саад болох бодит нөхцөл байдал үүссэн, тухайлбал уг этгээд хүндээр өвчилсөн, эсхүл тухайн этгээдийн хүсэлт гаргагч талын улсын нутаг дэвсгэр дэх байршлыг цаг тухайд нь тогтоох боломжгүй болсны улмаас шилжүүлэн өгч чадахгүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг сунгаж болно.

3. Аливаа этгээдийг шилжүүлэн өгөх боломжгүй тохиолдолд хүсэлт гаргагч Талын улсын эрх бүхий төв байгууллага нь хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллагад энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

6 дугаар зүйл
Хувийн мэдээллийг хамгаалах

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад Тал тус бүрийн улсын эрх бүхий байгууллага харилцан солилцсон, эсхүл бие биедээ илгээсэн хувийн мэдээллийг Тал тус бүрийн улсын хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль тогтоомж болон Тал тус бүрийн улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу хамгаална.

Түүнчлэн, дараахь зарчмыг баримтална:

a) хувийн мэдээллийг гагцхүү энэхүү хэлэлцээрийн зорилгоор ашиглана;

b) Тал тус бүрийн улсын эрх бүхий байгууллага энэхүү хэлэлцээрийн дагуу хүлээн авсан хувийн мэдээллийн нууцлалыг хадгалах ба уг мэдээллийг гаргаж өгсөн эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүнийг гуравдагч талд задруулахгүй бөгөөд тухайн мэдээллийг хэрхэн ашиглах тухайгаа мэдээлэл өгсөн эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ;

c) Тал тус бүрийн улсын эрх бүхий байгууллага хувь хүний мэдээллийг алдах, мэдээлэлд хууль бусаар нэвтрэх, түүнийг өөрчлөх, эсхүл задруулахаас хамгаална.

7 дугаар зүйл
Зардал

1. Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан этгээдийг буцаан шилжүүлэх болон түүнийг хүсэлт хүлээн авагч Талын улсын хилийн боомт хүртэл харгалзан дагалдаж хүргэхтэй холбогдон гарах зардлыг хэрэв тухайн хүн өөрөө, эсхүл гуравдагч тал төлөх боломжгүй бол хүсэлт гаргагч Тал хариуцна.

2. Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт дурдсан этгээдийг шилжүүлэх болон түүнийг хүсэлт хүлээн авагч Талын улсын хилийн боомт хүртэл харгалзан дагалдаж хүргэхтэй холбогдон гарах зардлыг тухайн этгээдийг үндэслэлгүйгээр буцаах нөхцөл байдалд хүргэсэн үйлдэл, эс үйлдэл хийсэн Тал хариуцна.

3. Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт дурдсан ярилцлага хийхтэй холбогдон гарах тээврийн зардлыг тухайн ярилцлага хийгдсэн этгээд өөрөө, эсхүл гуравдагч тал төлөх боломжгүй бол хүсэлт гаргагч Тал хариуцна.

8 дугаар зүйл
Гүйцэтгэх протокол

Талууд дараахь асуудлыг зохицуулах журмыг тусгасан гүйцэтгэх протокол байгуулна:

a) эрх бүхий байгууллагууд болон тэдгээрийн эрх хэмжээний хуваарилалт;

b) буцаан шилжүүлэх тухай хүсэлтийн агуулга,түүнийг хүргүүлэх журам;

c) ярилцлага хийх журам;

d) буцаан шилжүүлэх журам;

e) буцаан шилжүүлэх этгээдийг харгалзан дагалдаж шилжүүлэх;

f) энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг нөхөн төлөх журам.

9 дүгээр зүйл
Хэлэлцээрийн үйлчлэлийг түдгэлзүүлэх болон сэргээх

1. Тал тус бүр үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн хэв журмыг хангах, эсхүл хүн амын эрүүл мэндийг хамгаалах үүднээс энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно.

2. Аль нэг Тал энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг түдгэлзүүлсэн, эсхүл сэргээсэн тухайгаа уг шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс 72-оос доошгүй цагийн өмнө нөгөө Талдаа дипломат шугамаар бичгээр мэдэгдэнэ.

10 дугаар зүйл
Хамтын ажиллагааны зарчим

1. Талуудын хоорондын харилцаанд үүссэн болон энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх, эсхүл тайлбарлахтай холбогдон гарсан маргаантай бүх асуудлыг зөвлөлдөх болон хэлэлцээ хийх замаар шийдвэрлэнэ.

2. Зөвлөлдөх болон хэлэлцээ хийх журмыг Талууд тохиролцож тодорхойлно.

11 дүгээр зүйл
Олон улсын бусад гэрээтэй уялдах нь

1. Энэхүү хэлэлцээр аль ч Талын улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр тухайн Талын хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй.

2. Энэхүү хэлэлцээрийн аль ч заалт аль нэг Талын улсын нэгдэн орсон олон улсын бусад гэрээний үндсэн дээр аливаа эргэздийг буцаахад саад болохгүй.

12 дугаар зүйл
Төгсгөлийн заалт

1. Энэхүү хэлэлцээр нь Талууд түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын журмаа биелүүлсэн тухай бичгээр өгсөн сүүлчийн мэдэгдлийг дипломат шугамаар хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү хэлэлцээрт Талууд харилцан тохиролцож өөрчлөлт оруулж болох бөгөөд уг өөрчлөлт нь энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох журмын дагуу хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү хэлэлцээрийг тодорхой бус хугацаагаар байгуулсан бөгөөд аль нэг Талын хэлэлцээрийг хүчингүй болгох тухай бичгээр өгсөн мэдэгдлийг нөгөө Тал дипломат шугамаар хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 90 хоногийн дараа хүчингүй болно.

4. Энэхүү хэлэлцээр хүчингүй болсон тохиолдолд Талууд хэлэлцээр хүчинтэй байх хугацаанд үүссэн үүргийн биелэлтийг зохицуулж шийдвэрлэнэ.

Энэхүү хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 2014 оны 9 дүгээр сарын .....-ны өдөр монгол, орос, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Энэхүү хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарсан тохиолдолд англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ	ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

СОГЛАШЕНИЕ

МЕЖДУ ПРАВИТЕЛЬСТВОМ МОНГОЛИИ И ПРАВИТЕЛЬСТВОМ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ О РЕАДМИССИИ

Правительство Монголии и Правительство Российской Федерации, именуемые в дальнейшем Сторонами,

руководствуясь стремлением к развитию добрососедских и партнерских отношений между своими государствами, а также сотрудничества между ними в различных областях,

будучи убеждены, что введение в действие согласованных Сторонами принципов и норм, определяющих порядок возврата, приема и передачи лиц, находящихся на территории их государств в нарушение действующего порядка въезда и пребывания иностранных граждан и лиц без гражданства, является важной составной частью регулирования процессов миграции и вкладом в борьбу с незаконной миграцией,

уважая суверенное право каждого из государств Сторон в соответствии с его законодательством устанавливать ответственность за незаконную миграцию на его территории или через нее иностранных граждан и лиц без гражданства,

подчеркивая, что настоящее Соглашение не умаляет прав, обязательств и ответственности государств Сторон по международному праву, включая нормы международного права, закрепленные, в частности, во Всеобщей декларации прав человека от 10 декабря 1948 г., в Конвенции против пыток и других жестоких, бесчеловечных или унижающих достоинство видов обращения и наказания от 10 декабря 1984 г.,

отмечая возрастающую заинтересованность государств Сторон в гармонизации их национальных законодательств в области миграции,

согласились о нижеследующем:

Статья 1
Определения

Понятия, используемые в настоящем Соглашении, означают следующее:

«реадмиссия» - передача компетентными органами государства запрашивающей Стороны и прием компетентными органами государства запрашиваемой Стороны в порядке, на условиях и в целях, которые предусмотрены настоящим Соглашением, лиц, въехавших или находящихся на территории государства запрашивающей Стороны в нарушение законодательства этого государства по вопросам въезда, выезда и пребывания иностранных граждан и лиц без гражданства;

«запрашивающая Сторона» - Сторона, центральный компетентный орган государства которой направляет запрос о реадмиссии лица в соответствии с настоящим Соглашением;

«запрашиваемая Сторона» - Сторона, в адрес центрального компетентного органа государства которой направлен запрос о реадмиссии лица в соответствии с настоящим Соглашением;

«компетентные органы» - органы государств Сторон, участвующие в реализации настоящего Соглашения;

«центральный компетентный орган» - компетентный орган государства каждой из Сторон, на который возложены основные задачи по реализации настоящего Соглашения;

«пункт пропуска через государственную границу» пункт пропуска через государственную границу Монголии или государственную границу Российской Федерации, установленный в соответствии с законодательством государства каждой из Сторон или международными договорами;

«Исполнительный протокол» - Исполнительный протокол о порядке реализации настоящего Соглашения.

Статья 2
Реадмиссия граждан государств Сторон

1. Компетентные органы государства запрашиваемой Стороны принимают по запросу центрального компетентного органа государства запрашивающей Стороны лиц, которые въехали или находятся на территории государства запрашивающей Стороны с нарушением законодательства этого государства по вопросам въезда, выезда и пребывания иностранных граждан и лиц без гражданства, если установлено, что они являются гражданами государства запрашиваемой Стороны, а также граждан государства запрашиваемой Стороны, отбывших наказание в виде лишения свободы на территории государства запрашивающей Стороны.2. В случае необходимости компетентные органы государства запрашиваемой Стороны

выдают лицу, подлежащему реадмиссии, независимо от его волеизъявления документы, необходимые для его въезда на территорию этого государства.

3. Документы, на основании которых определяется наличие у лица гражданства государства запрашиваемой Стороны, приводятся в Исполнительном протоколе. Стороны в течение 30 календарных дней с даты вступления в силу Исполнительного протокола обмениваются по дипломатическим каналам образцами указанных документов. В последующем каждая из Сторон незамедлительно уведомляет другую Сторону по дипломатическим каналам о любых изменениях в таких документах.

4. Если ни один из документов, предусмотренных пунктом 3 настоящей статьи, не может быть представлен, компетентные органы государств Сторон договариваются о проведении на территории государства запрашивающей Стороны собеседования с лицом, подлежащим реадмиссии, в целях получения сведений о его гражданстве.

5. Компетентные органы государства запрашивающей Стороны принимают обратно переданное ими лицо в течение 30 календарных дней с даты его передачи, если полученные запрашиваемой Стороной после передачи лица результаты проверки будут свидетельствовать об отсутствии условий, необходимых для его реадмиссии (ошибочная реадмиссия). В этом случае центральный компетентный орган государства запрашиваемой Стороны передает центральному компетентному органу государства запрашивающей Стороны все имеющиеся в его распоряжении материалы, касающиеся этого лица.

Статья 3
Запрос о реадмиссии

1. Для передачи лица, подлежащего реадмиссии, необходимо направление центральным компетентным органом государства запрашивающей Стороны запроса о реадмиссии центральному компетентному органу государства запрашиваемой Стороны.

2. Направление запроса о реадмиссии не требуется, когда лицо, подлежащее реадмиссии, имеет действительный документ, удостоверяющий личность гражданина государства запрашиваемой Стороны. Передача таких лиц осуществляется в соответствии с процедурой реадмиссии, указанной в статье 7 Исполнительного протокола.

Статья 4
Сроки направления и рассмотрения запросов о реадмиссии

1. Запрос о реадмиссии направляется центральным компетентным органом государства запрашивающей Стороны по результатам установления факта незаконного въезда на территорию государства запрашивающей Стороны или незаконного пребывания граждан государства запрашиваемой Стороны на территории государства запрашивающей Стороны.

2. Центральный компетентный орган государства запрашиваемой Стороны в течение 30 календарных дней с даты получения запроса о реадмиссии дает согласие на прием или мотивированный отказ в его приеме, если компетентными органами государства запрашиваемой Стороны установлено отсутствие необходимых для передачи этого лица условий, предусмотренных пунктом 1 статьи 2 настоящего Соглашения. При наличии обстоятельств юридического или фактического характера, препятствующих своевременному ответу на запрос о реадмиссии, сроки ответа на основании мотивированного обращения центрального компетентного органа государства запрашиваемой Стороны продлеваются до 60 календарных дней.

3. При отклонении запроса о реадмиссии указываются его причины.

Статья 5
Сроки передачи и приема лиц

1. Передача лиц, в отношении которых запрашиваемой Стороной дано согласие на реадмиссию, осуществляется в течение 30 календарных дней с даты получения такого согласия запрашивающей Стороной, если центральные компетентные органы государств Сторон в каждом конкретном случае не договорятся об ином.

2. Срок, указанный в пункте 1 настоящей статьи, может быть продлен, если лицо, подлежащее реадмиссии, не может быть передано компетентному органу государства запрашиваемой Стороны по причине возникновения обстоятельств, объективно препятствующих возврату, в частности тяжелой болезни лица, подлежащего реадмиссии, или невозможности своевременного установления его местонахождения на территории государства запрашивающей Стороны.

3. При невозможности передачи лица центральный компетентный орган государства запрашивающей Стороны направляет центральному компетентному органу государства запрашиваемой Стороны соответствующее письменное уведомление.

Статья 6
Защита персональных данных

Персональные данные, которыми компетентные органы государств Сторон обмениваются или которые передают друг другу в связи с реализацией положений настоящего Соглашения, подлежат защите в государстве каждой из Сторон в соответствии с его законодательством о защите персональных данных и международными договорами, участниками которых являются государства Сторон.

Кроме того, применяются следующие принципы:

a) персональные данные используются только для целей настоящего Соглашения;

b) компетентные органы государств Сторон обеспечивают конфиденциальность персональных данных, получаемых в соответствии с настоящим Соглашением, не предоставляют их третьей стороне, кроме как с письменного разрешения компетентных органов, передавших персональные данные, и уведомляют компетентные органы, передавшие такие данные, об их использовании;

c) компетентные органы государств Сторон обеспечивают защиту персональных данных от утери, неправомерного доступа, изменения или предания гласности.

Статья 7
Расходы

1. Расходы, связанные с реадмиссией и возможным сопровождением лиц, указанных в пункте 1 статьи 2 настоящего Соглашения, до пункта пропуска через государственную границу государства запрашиваемой Стороны, несет запрашивающая Сторона в случае, если расходы не могут быть оплачены указанными лицами самостоятельно или третьей стороной.

2. Расходы, связанные с передачей лиц, указанных в пункте 5 статьи 2 настоящего Соглашения, и их возможным сопровождением до пункта пропуска через государственную границу государства запрашивающей Стороны, несет Сторона, действия или бездействие которой привели к передаче лица, основания для реадмиссии которого отсутствовали.

3. Транспортные расходы, связанные с проведением собеседований, предусмотренных пунктом 4 статьи 2 настоящего Соглашения, несет запрашивающая Сторона в случае, если расходы не могут быть оплачены лицом, с которым проводится собеседование, самостоятельно или третьей стороной.

Статья 8
Исполнительный протокол

Стороны заключают Исполнительный протокол, который содержит в том числе правила, касающиеся:

a) компетентных органов и распределения полномочий между ними;

b) содержания и порядка направления запроса о реадмиссии;

c) проведения собеседований;

d) процедуры реадмиссии;

e) передачи лиц с сопровождением;

f) порядка возмещения расходов, связанных с выполнением настоящего Соглашения.

Статья 9
Приостановление и возобновление применения Соглашения

1. Каждая Сторона может по причинам, связанным с защитой национальной безопасности, обеспечением общественного порядка или охраной здоровья населения, частично или полностью приостановить применение настоящего Соглашения.

2. О приостановлении или возобновлении применения настоящего Соглашения одна Сторона уведомляет в письменной форме по дипломатическим каналам другую Сторону не позднее 72 часов до начала реализации такого решения.

Статья 10
Принципы сотрудничества

1. Все спорные вопросы, возникающие в отношениях между Сторонами и связанные с реализацией или толкованием настоящего Соглашения, решаются путем консультаций и переговоров между ними.

2. Порядок осуществления консультаций и переговоров определяется по договоренности Сторон.

Статья 11
Отношение к другим международным договорам

1. Настоящее Соглашение не затрагивает прав и обязательств каждой из Сторон, вытекающих из других международных договоров, участником которых является ее государство.

2. Ничто в настоящем Соглашении не препятствует возвращению того или иного лица на основании других международных договоров, участником которых является государство одной из Сторон.

Статья 12
Заключительные положения

1. Настоящее Соглашение вступает в силу по истечении 30 календарных дней с даты получения по дипломатическим каналам последнего письменного уведомления о выполнении Сторонами внутригосударственных процедур, необходимых для его вступления в силу.

2. Стороны по взаимному согласию могут вносить изменения в настоящее Соглашение, которые вступают в силу в порядке, предусмотренном для вступления в силу настоящего Соглашения.

3. Настоящее Соглашение заключается на неопределенный срок и его действие прекращается по истечении 90 календарных дней с даты получения одной Стороной по дипломатическим каналам письменного уведомления другой Стороны о ее намерении прекратить его действие.

4. В случае прекращения действия настоящего Соглашения Стороны урегулируют обязательства, возникшие в период его действия.

Совершено в г. Улан-Баторе «__» сентября 2014 г. в двух экземплярах, каждый на монгольском, русском и английском языках, причем все тексты имеют одинаковую силу.

В случае разногласий при толковании настоящего Соглашения Стороны используют текст на английском языке.

ЗА ПРАВИТЕЛЬСТВО МОНГОЛИИ	ЗА ПРАВИТЕЛЬСТВО РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ

AGREEMENT
BETWEEN THE GOVERNMENT OF MONGOLIA AND
THE GOVERNMENT OF THE RUSSIAN FEDERATION
ON READMISSION

The Government of Mongolia and the Government of the Russian Federation, hereinafter referred to as the Parties,

guided by the desire to develop between their States the relations of good-neighborliness and partnership, as well as cooperation in various fields,

being convinced that introduction of principles and standards agreed upon by the Parties, setting the procedure for the return, admission and transfer of persons staying in the territory of their States in violation of the applicable procedure of entry and stay of foreign nationals and stateless persons is an important element of regulating migration processes and the contribution into the fight against illegal migration,

respecting the sovereign right of each State of the Parties to establish, in accordance with its legislation, responsibility for the illegal migration into or through its territory of foreign nationals and stateless persons,

emphasizing that this Agreement does not prejudice the rights, liabilities and responsibility of the States of the Parties under the international law set forth, in particular, in the Universal Declaration of Human Rights of 10 December 1948; the Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment of 10 December 1984,

noting the growing interest of the States of the Parties in harmonizing their respective national legislation in the field of migration,

have agreed as follows:

Article 1
Definitions

In this Agreement the terms given below shall have the following meaning:

"readmission" – the transfer by the competent authorities of the State of the requesting Party and admission by the competent authorities of the State of the requested Party, according to the procedure, conditions and purposes set forth in this Agreement, of persons who have entered into or stay in the territory of the State of the requesting Party in violation of the legislation of that State on entry, exit and stay of foreign nationals and stateless persons;

"requesting Party" – the Party whose central competent authority of the State submits a readmission request of a person in accordance with this Agreement;

"requested Party" – the Party to which central competent authority of the State a readmission request is addressed in accordance with Agreement;

"competent authorities" – the authorities of the States of the Parties entrusted with the implementation of this Agreement;

"central competent authority" – the competent authority of the State of each Parties which carries the main responsibility for the implementation of the Agreement;

"border crossing point" – border crossing point of Mongolia or border crossing point of the Russian Federation, established in accordance with the legislation of both Parties or international treaties;

"Implementing protocol" – the Implementing Protocol on the procedure for the implementation of this Agreement.

Article 2
Readmission of citizens of the States of the Parties

1. The competent authorities of the State of the requested Party shall admit, upon the request of the central competent authorities of the State of the requesting Party, persons who have entered into or stay in the territory of the State of the requesting Party in violation of the legislation of that State on entry, exit and stay of foreign nationals and stateless persons, if it has been proved that they are nationals of the State of the requested Party, as well as nationals of the State of the requested Party, who have served prison punishment in the form of deprivation of liberty on the territory of the State of the requesting Party.

2. If necessary, the competent authorities of the State of the requested Party shall issue to the person to be readmitted, irrespective of his/her will, the documents necessary for his/her entry into the territory of that State.

3. The documents forming the basis for proving the presence of the persons' citizenship of the State of the requested Party are specified in the Implementing Protocol. Within 30 calendar days from the date of entry into the force of the Implementing protocol, the Parties shall exchange through diplomatic channels the specimens of the abovementioned documents. Subsequently, each Party shall notify

immediately the other Party through diplomatic channels, of any changes in the specimens of these documents.

4. If none of the documents specified in paragraph 3 of this Article cannot be presented, the competent authorities of the States of the Parties shall agree to organize in the territory of the State of the requesting Party the interview with a person to be readmitted in order to collect any data concerning his/her citizenship.

5. The competent authorities of the State of the requesting Party shall admit back the transferred person within period of 30 calendar days from the date of his/her transfer if the results of the examination received by the requested Party after the transfer of the person prove the absence of necessary conditions for his/her readmission (readmission in error). In this case the central competent authority of the State of the requested Party shall transfer to the central competent authority of the State of the requesting Party all the materials at its disposal in respect of the person in question.

Article 3
Readmission request

1. For the transfer of a person to be readmitted, there shall be required the submission of a readmission request by the central competent authority of the State of the requesting Party to the central competent authority of the State of the requested Party.

2. The readmission request shall not be needed when the person to be readmitted is in possession of a valid identity card of the citizens of the State of the requested Party. The transfer of such persons shall be carried out in accordance with the readmission procedure mentioned in Article 7 of the Implementing protocol.

Article 4
Time limits for the submission and consideration of the readmission request

1. A readmission request can be submitted by central competent authority of the requesting Party upon the results of establishment of the fact of illegal entry into the territory of the State of the requesting Party or the illegal stay of citizens of the State of the requested Party on the territory of the State of the requesting Party.

2. Within 30 calendar days from the date of receipt of the readmission request the central competent authority of the State of the requested Party shall give its consent for readmission or the reasonable refuse if the competent authorities of the State of the requested Party determine the absence of conditions for the transfer of that person, as provided for by paragraph 1 of Article 2 of this Agreement. Where there are legal or factual obstacles for timely reply to the readmission request of the person, the time limits shall, upon duly motivated written request of the central competent authority of the State of the requested Party, be extended up to 60 calendar days.

3. Reasons shall be given for refusal of a readmission request.

Article 5
Time limits for transfer and admission of persons

1. Unless the central competent authorities of the States of the Parties agree otherwise in each particular case, the transfer of persons in respect of whom the requested Party has given its consent for readmission, shall be made within 30 calendar days from the date of the receipt of such consent by the requesting Party.

2. The time limit specified in paragraph 1 of this Article may be extended if the person to be readmitted cannot be transferred to the competent authority of the State of the requested Party due to occurrence of circumstances objectively preventing the transfer, in particular, serious illness of the person to be readmitted or the impossibility of timely identification of his/her location in the territory of the State of the requesting Party.

3. If it is impossible to transfer a person, the central competent authority of the State of the requesting Party shall forward a relevant written notification to the central competent authority of the State of the requested Party.

Article 6
Personal data protection

The personal data which the competent authorities of the States of the Parties shall exchange or sent to each other in connection with the implementation of this Agreement shall be protected in the State of each Party in compliance with its legislation on personal data protection and international treaties to which the States of the Parties are participants.

In addition, the following principles shall apply:

a) personal data must be used only for the purposes of this Agreement;

b) the competent authorities of the States of Parties shall provide for confidentiality of the personal data received under this Agreement, shall not disclose such data to a third party, unless authorized in writing by the competent authorities, submitting such personal data, and shall notify the competent authorities, which has submitted such personal data, on the manner such data will be used in;

c) the competent authorities of the States of the Parties shall ensure protection of the personal data from the loss, illegal access, alteration or disclosure.

Article 7
Costs

1. The costs incurred in connection with the readmission and possible escorting of the persons referred to in paragraph 1 of Article 2 of this Agreement to the border crossing point of the State of the requested Party, shall be borne by the requesting Party, unless these costs can be paid by such persons by themselves or by a third party.

2. The costs incurred in connection with the transfer of persons specified in paragraph 5 of Article 2 of this Agreement and their possible escorting up to the border crossing point of the State of the requesting Party, shall be borne by the Party action or inaction of which led to the situation when the person transferred without grounds for the readmission.

3. Transport costs incurred in connection with carrying out of the interview referred to in paragraph 4 of Article 2 of this Agreement shall be borne by the requesting Party unless such costs can be paid by persons subject to the interview or by third party.

Article 8
Implementing protocol

The Parties conclude an Implementing protocol, which covers rules on, including:

a) the competent authorities and distribution of competence between them;

b) the content and procedure of forwarding of the readmission request;

c) the procedure of interviewing;\

d) the procedure of the readmission;

e) the transfer of persons with escorting;

f) the procedure of the cost reimbursement related to the implementation of this Agreement.

Article 9
Suspension and resumption of application of the Agreement

1. Each Party may suspend this Agreement, either in whole or in part, for the reasons of national security, public order or public health.

2. One Party shall notify the other Party in writing, on the suspension or resumption of this Agreement through diplomatic channels not later than 72 hours before this decision enters into force.

Article 10
Principles of cooperation

1. All disputable questions arising in relationships between the Parties and connected with the implementation or interpretation of this Agreement shall be settled by the consultations and negotiations between them.

2. The procedure of consultation and negotiation shall be determined by the arrangement between the Parties.

Article 11
Relationship with other international treaties

1. This Agreement shall not affect the rights and obligations of either Party arising from other international treaties to which its State is a Party.

2. Nothing in this Agreement shall prevent the return of this or that person on the basis of other international treaties to which the State of one of the Parties is a party to.

Article 12
Final provisions

1. This Agreement shall enter into force on the date following after the expiration of 30 calendar days after the date of receiving through diplomatic channels of the last written notification of the fulfillment by the Parties of their internal procedures necessary for its entry into force.

2. The Parties may upon mutual consent make amendments to this Agreement, which shall enter into force according to the procedure provided for the entry into force of this Agreement.

3. This Agreement shall be concluded for an indefinite period and shall be terminated after the expiration of 90 calendar days from the date of receipt by one of the Parties through diplomatic channels of a written notification of the other Party of its intention to terminate it.

4. In case of termination of this Agreement the Parties shall settle the obligations which have arisen during the period of its action.

Done at Ulaanbaatar on the ___of September 2014 in two original copies, each in the Mongolian, Russian, and English languages, all texts being equally authentic.
In case of divergence in interpretation of this Agreement, the English text shall prevail

FOR THE GOVERNMENT OF MONGOLIA	FOR THE GOVERNMENT OF THE RUSSIAN FEDERATION

ХУУЛЬ БУСААР БАЙГАА ИРГЭДИЙГ БУЦААН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ГҮЙЦЭТГЭХ ПРОТОКОЛ

Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар (цаашид "Талууд" гэх),

2014 оны 9 дүгээр сарын ....-ны өдөр байгуулсан Хууль бусаар байгаа иргэдийг буцаан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр (цаашид "хэлэлцээр" гэх)-ийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг аль болох бүрэн зохицуулах харилцан сонирхолтой буйгаа илэрхийлж,

дараахь зүйлийг тохиролцов:

1 дүгээр зүйл
Эрх бүхий байгууллага

1. Хэлэлцээрийн заалтын хэрэгжилтийг хариуцсан эрх бүхий байгууллага нь:

Монгол Улсын хувьд:

эрх бүхий төв байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар;

эрх бүхий байгууллага нь Монгол Улсын Гадаад харилцааны яам болон Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газар.

Оросын Холбооны Улсын хувьд:

эрх бүхий төв байгууллага нь Холбооны шилжилт хөдөлгөөний алба;

эрх бүхий байгууллага нь Оросын Холбооны Улсын Гадаад хэргийн яам болон Оросын Холбооны Улсын Холбооны аюулгүй байдлын алба байна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан эрх бүхий байгууллага өөрчлөгдсөн тохиолдолд Талууд бие биедээ дипломат шугамаар нэн даруй мэдэгдэнэ.

3. Хэлэлцээр болон энэхүү гүйцэтгэх протоколын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Талуудын улсын эрх бүхий төв байгууллагууд хоорондоо шууд харилцаж, хамтран ажиллана.

4. Энэхүү гүйцэтгэх протоколыг хэрэгжүүлэх зорилгоор Талуудын улсын эрх бүхий төв байгууллагууд холбоо барихад шаардлагатай мэдээллээ гүйцэтгэх протоколд гарын үсэг зурсан өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн дотор бие биедээ дипломат шугамаар, бичгээр өгнө.

5. Талуудын улсын эрх бүхий төв байгууллагууд тэдгээртэй холбоо барихад шаардлагатай мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд бие биедээ бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

2 дугаар зүйл
Иргэний харьяаллыг нотлох баримт

1. Оросын Холбооны Улсын иргэний харьяалалтайг дараахь бичиг баримтаар нотолно:

a) дипломат паспорт;
b) албан паспорт;
c) Оросын Холбооны Улсын иргэн болохыг нь Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэрийн гадна нотлох Оросын Холбооны Улсын иргэний паспорт;
d) Оросын Холбооны Улсын иргэний паспорт;
e) Оросын Холбооны Улсын иргэний харьяалалтайг нотлох хавсралт бүхий цэргийн албан хаагчийн хувийн байдлыг тогтоох үнэмлэх (цэргийн үнэмлэх);
f) Оросын Холбооны Улсад орох (буцах) үнэмлэх;
g) Оросын Холбооны Улсын иргэний харьяалалтайг нотлох хавсралт бүхий төрсний гэрчилгээ;
h) Эцэг, эх нь, тэдний аль нэг нь, эсхүл ганц бие эцэг, эх нь Оросын Холбооны Улсын иргэний харьяалалтайг нотлох хавсралт бүхий төрсний гэрчилгээ;
i) Оросын Холбооны Улсын иргэний харьяалалтайг нотлох тэмдэглэгээ бүхий төрсний гэрчилгээ;

j) хэрэв хүүхдийн тухай мэдээлэл агуулсан бөгөөд Оросын Холбооны Улсын холбогдох эрх бүхий байгууллагын албан тушаалтны гарын үсэг, тамгаар баталгаажсан бол тухайн хүүхдийн иргэний харьяаллыг нотолж буй энэ хэсгийн a-d дэд хэсэгт дурдсан бичиг баримт.

2. Монгол Улсын иргэний харьяалалтайг дараахь бичиг баримтаар нотолно:

a) дипломат паспорт;
b) албан паспорт;
c) Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт;
d) Монгол Улсын иргэний үнэмлэх;
e) Монгол Улсад буцах үнэмлэх;
f) төрсний гэрчилгээ;
g) Монгол Улсын иргэний харьяалалтайг нотолсон эрх бүхий байгууллагын лавлагаа;
h) хэрэв хүүхдийн тухай мэдээлэл агуулсан бөгөөд Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагын тамгаар баталгаажсан бол тухайн хүүхдийн иргэний харьяаллыг нотолж буй энэ хэсгийн a-c дэд хэсэгт дурдсан бичиг баримт.

3. Тухайн этгээд дараахь бичиг баримттай бол түүнийг Оросын Холбооны Улсын иргэн хэмээн үзэж болно:

a) энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан, хүчинтэй хугацаа нь дуусан бичиг баримт;
b) энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан бичиг баримтын хуулбар, эсхүл хувь;
c) далайчны паспорт (далайчны хувийн байдлын үнэмлэх);
d) Оросын Холбооны Улсын иргэний харьяалалтайг нотлох хавсралт бүхий ЗСБНХУ-ын иргэний паспорт;
e) Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэрт оршин сууж буй хаягаар 1992 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн байдлаар бүртгэл хийлгэсэн тэмдэг бүхий ЗСБНХУ-ын иргэний паспорт;
f) Орос-Монголын улсын хилийг нэг удаа хоёр тал руу нэвтрэх үнэмлэх;
g) Оросын Холбооны Улсын эрх бүхий байгууллагаас олгосон, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг бусад бичиг баримт;
h) буцаан шилжүүлэх этгээдийн энэхүү гүйцэтгэх протоколын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу үйлдсэн мэдүүлэг;
i) эрх бүхий холбогдох байгууллага гэрчээс хуулийн дагуу бичгээр авсан тайлбар;
j) холбогдох албан тушаалтны бичгээр гаргасан тайлбар;
k) буцаан шилжүүлэх этгээдтэй хийсэн ярилцлагын эерэг үр дүн.

4. Тухайн этгээд дараахь бичиг баримттай бол түүнийг Монгол Улсын иргэн хэмээн үзэж болно:

a) энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан, хүчинтэй хугацаа нь дуусан бичиг баримт;
b) энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бичиг баримтын хуулбар, эсхүл хувь;
c) 2000 он хүртэл ашиглагдаж байсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын иргэний паспорт;
d) Монгол Улсын иргэний харьяалалтай болохыг нотолсон хавсралт бүхий Бүгд Найрамдах Монгол Ард Улсын иргэний паспорт;
e) эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн паспортад хавсаргасан хүүхдийн хавсралт үнэмлэх;
f) 5 хүртэлх насны хүүхдийн фото зураг бүхий эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн паспорт;
g) Монгол-Оросын улсын хилийг нэг удаа хоёр тал руу нэвтрэх үнэмлэх;
h) Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон, энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасныг бусад бичиг баримт;
i) буцаан шилжүүлэх этгээдийн энэхүү гүйцэтгэх протоколын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу үйлдсэн мэдүүлэг;
j) эрх бүхий холбогдох байгууллага гэрчээс хуулийн дагуу бичгээр авсан тайлбар;
k) холбогдох албан тушаалтны бичгээр гаргасан тайлбар;
l) буцаан шилжүүлэх этгээдтэй хийсэн ярилцлагын эерэг үр дүн.

3 дугаар зүйл
Бусад бичиг баримт

1. Энэхүү гүйцэтгэх протоколын 2 дугаар зүйлд заагаагүй боловч хүсэлт гаргагч Талын үзэж буйгаар буцаан шилжүүлэх этгээдийн иргэний харьяаллыг тогтооход чухал ач холбогдолтой байж болох бичиг баримтыг буцаан шилжүүлэх тухай хүсэлтэд хавсаргаж болно.

2. Хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллага буцаан шилжүүлэх тухай хүсэлтийг шийдвэрлэх явцдаа энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан бичиг баримтыг харгалзаж үзэх эсэхийг шийднэ.

4 дүгээр зүйл
Ярилцлага

1. Хүсэлт гаргагч Талын улсын эрх бүхий төв байгууллагын хүсэлтээр хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан этгээдтэй хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу ярилцлага хийх үндсэн үүргийг хүсэлт гаргагч Талын улсад байгаа хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллагын төлөөлөгч хүлээнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллагын төлөөлөгч байхгүй тохиолдолд ярилцлагыг хүсэлт гаргагч Талын улсад суугаа хүсэлт хүлээн авагч Талын улсын дипломат төлөөлөгчийн газрын, эсхүл консулын газрын албан тушаалтан хийнэ.

3. Хүсэлт гаргагч Талын улсын нутаг дэвсгэрт байгаа хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллагын төлөөлөгч, эсхүл энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан тохиолдолд дипломат төлөөлөгчийн газрын, эсхүл консулын газрын албан тушаалтан ярилцлага хийх талаар энэхүү гүйцэтгэх протоколын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үйлдсэн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 14 хоногийн дотор ярилцлага хийнэ.

4. Тал бүрийн улсын эрх бүхий байгууллагууд ярилцлага хийх газар, он, сар, өдөр, цагийг тухайн тохиолдол бүрт харилцан тохиролцоно.

5 дугаар зүйл
Буцаан шилжүүлэх тухай хүсэлтийн агуулга, түүнийг хүргүүлэх болон хүсэлтэд хариу өгөх журам

1. Хүсэлт гаргагч Талын улсын эрх бүхий төв байгууллага буцаан шилжүүлэх тухай хүсэлтийг энэхүү гүйцэтгэх протоколын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бичгээр үйлдэж хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллагад шуудангаар, эсхүл элчээр хүргүүлнэ.

2. Буцаан шилжүүлэх этгээдийг хүсэлт хүлээн авагч Талын улсын иргэн болохыг нотлох, эсхүл тухайн улсын иргэн гэж үзэхүйц үндэслэл болох, хүсэлт гаргагч Талд байгаа бөгөөд энэхүү гүйцэтгэх протоколын 2 болон 3 дугаар зүйлд заасан бичиг баримтыг буцаан шилжүүлэх тухай хүсэлтэд хавсаргана.

3. Хүсэлт гаргагч Талын улсын эрх бүхий төв байгууллага шаардлагатай тохиолдолд тухайн буцаан шилжүүлэх этгээдийн онц аюултай байдал болон эрүүл мэндийн талаарх нэмэлт мэдээллийг буцаан шилжүүлэх тухай хүсэлтийн "В" хэсэгт тусгана.

4. Хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллага буцаан шилжүүлэх тухай хүсэлтийн хариуг бичгээр үйлдэж, хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд хүсэлт гаргагч Талын улсын эрх бүхий төв байгууллагад шуудангаар, эсхүл элчээр хүргүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд мэдээлэл дамжуулах техник хэрэгслээр нэмж илгээнэ.

6 дугаар зүйл
Буцаан шилжүүлэх этгээдийг харгалзан дагалдах

1. Буцаан шилжүүлэх этгээдийг харгалзан дагалдаж хүргэх шаардлагатай бол хүсэлт гаргагч Талын улсын эрх бүхий төв байгууллагаас

хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий төв байгууллагад харгалзан дагалдаж яваа хүмүүсийн овог, нэр, албан тушаал, паспортын төрөл, дугаар, олгосон он, сар, өдөр, хүчинтэй байх хугацаа, мөн хүсэлт хүлээн авагч Талын улсын нутаг дэвсгэрт зорчихоор төлөвлөж буй хугацааны талаарх мэдээллийг хүргүүлнэ.

2. Харгалзан дагалдаж яваа хүмүүс нь хүсэлт хүлээн авагч Талын улсын нутаг дэвсгэрт зорчих хугацаандаа тухайн улсын хууль тогтоомжийг сахин биелүүлэх үүрэгтэй.

3. Харгалзан дагалдаж яваа хүмүүс нь энгийн хувцас өмсөж, хүчин төгөлдөр паспорт болон буцаан шилжүүлэх ажиллагааг тохиролцсоны дагуу гүйцэтгэж байгааг нотолсон бичиг баримтыг биедээ авч явна.

4. Харгалзан дагалдаж яваа хүмүүс нь биедээ зэвсэг болон хүсэлт хүлээн авагч Талын улсын нутаг дэвсгэрт хэрэглээг хязгаарласан, эсхүл хэрэглэхийг хориглосон бусад зүйлийг авч явж болохгүй.

5. Тал тус бүрийн улсын эрх бүхий байгууллагууд харгалзан дагалдаж яваа хүмүүсийг хүсэлт хүлээн авагч Талын улсын нутаг дэвсгэрт зорчихтой холбоотой бүх асуудлаар хамтран ажиллана. Хүсэлт хүлээн авагч Талын улсын эрх бүхий байгууллага шаардлагатай тохиолдолд харгалзан дагалдаж яваа хүмүүст бололцоотой дэмжлэг үзүүлнэ.

7 дугаар зүйл
Буцаан шилжүүлэх журам

1. Тал тус бүрийн улсын иргэдийг буцаан шилжүүлэх ажиллагааг Талуудын улсын хилийн бүх боомтоор явуулна.

2. Буцаан шилжүүлэх он, сар, өдөр, цаг, мөн энэ зорилгоор ашиглах Тал тус бүрийн улсын хилийн боомтыг Тал тус бүрийн улсын эрх бүхий байгууллагууд тухайн тохиолдол бүрт тохиролцож тодорхойлно.

